



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 20 өдөр

Дугаар A/413

Улаанбаатар хот

Г Сургалтын төрийн сангийн зээлийн  
санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах тухай” 78 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны “Журам шинэчлэн батлах, журамд өөрчлөлт оруулах тухай” 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам”, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны “Журам, чиглэл шинэчлэн батлах тухай” 71 дүгээр тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2013 оны “Журам батлах тухай” А/316 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутныг сонгон шалгаруулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Алтай овогтой Мөнхцацалыг ХБНГУ-ын Гунбольдын их сургуульд хөгжим судлаачийн чиглэлээр докторантурт 1 жил, Дашпүрэв овогтой Пүрэвбаатарыг О.Е.Кутафина нэрэмжит Москвагийн хууль зүйн улсын их сургуульд эрх зүйн чиглэлээр аспирантурт 3 жил, Даваажав овогтой Бат-Өлзийг ОХУ-ын Дотоод хэргийн яамны Москва хотын их сургуульд эрх зүйн чиглэлээр адъюнктурт 3 жил 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн Сургалтын Төрийн сангийн зээлийн санхүүжилтээр суралцуулсугай.

2. Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай” 2014 оны А/219 дүгээр тушаалын хавсралтад байгаа “Шагдаржав овогтой Эрдэнэсувд University of Sydney-д мэдээллийн технологийн мэргэжлээр 4 жил” гэснийг “Шагдаржав овогтой Эрдэнэсувд University of Queensland-д мэдээллийн технологийн мэргэжлээр 4 жил” гэж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Тушаалд нэмэлт оруулах тухай” 2014 оны А/319 дүгээр тушаалын хавсралтад байгаа “Сод-Эрдэнэ овогтой Хас-Очир University of Arizona-д Хөдөө аж ахуйн эдийн засаг мэргэжлээр 4 жил” гэснийг “Сод-Эрдэнэ овогтой Хас-Очир University of Arozona-д инженерийн мэргэжлээр 4 жил” гэж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай” 2013 оны А/57 дугаар тушаалын хавсралтад байгаа “Төмөртогоо овогтой Алигирмаа АНУ-ын Бостон дахь Массачусеттийн их сургуульд улс төр судлал мэргэжлээр бакалаврын сургалтад 2 жил” гэснийг “Төмөртогоо овогтой Алигирмаа АНУ-ын Бостон дахь Массачусеттийн их сургуульд улс төр судлал мэргэжлээр бакалаврын сургалтад 4 жил” гэж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Сургалтын төрийн сангаас сургалтын

төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох тухай” 2012 оны А/200 дугаар тушаалын “Бат-Амгалан овогтой Санжаажавыг Австри Улсын Венийн их сургуульд хөгжим судлалын мэргэжлээр 2012-2013 оны хичээлийн жилд” гэснийг “Бат-Амгалан овогтой Санжаажавыг Австри Улсын Венийн их сургуульд хөгжим судлалын мэргэжлээр 2012-2013 оны хичээлээс 2 жил” гэж өөрчилсүгэй.

3. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Мөнхцэцэг/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР